



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№190 /400/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.10.24

Цаг үе, үйл явдал

АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН СУРГУУЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО



Агаарын цэргийн тус командлалын штабын дарга зорилт, баримтлах бодлого болон командлалын 2022-2023 оны бригадын генерал Б.Эрдэнэбат энэ сургуулийн жилийг "Залуу сургуулийн жилийн нээлт шинэ сургуулийн жилийн зорилго, офицеруудын манлайлал"-ын жил

болгон зарласантай холбоотой хийгдэх ажлын төлөвлөгөө, цэргийн дүрмийн шинэчлэл зэрэг сэдвээр Агаарын цэргийн командлалын бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийж, үүрэг чиглэл өглөө.

Үргэлжлүүлэн Удирдлагын академийн доктор багш Т.Түмэнцогтоо "Төрийн байгууллагын стратеги, алсын хараа, соёл", бэлтгэл хурандаа Э.Төмөр "Хүний хөгжлийн Монгол ухаан" сэдвээр тус тус илтгэлээ танилцуулсан юм.

Мөн энэ үеэр Агаарын цэргийн командлалын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга хурандаа Г.Чулуунзагд командлалын дүрмийн нэмэлт өөрчлөлт, Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн ахлах офицер хурандаа Ч.Буянзаяа командлалын цэргийн алба зохион байгуулах командлагчийн тушаалыг танилцуулав.

Хоёр өдөр үргэлжилсэн тус үйл ажиллагааны хүрээнд Агаарын цэргийн командлалын бүрэлдэхүүн Налайх районд 30км-ийн явган марш үйлдэн, инженер, хими, холбооны бэлтгэл, амьд гарах арга ухаан зэрэг хичээлийн бэлтгэсэн цэгүүдээр үүрэг гүйцэтгэсэн юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 14	☁️ -3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.406.00	3.420.0
EUR 🇪🇺	3.385.0	3.410.0
CNY 🇨🇳	469	473
RUB 🇷🇺	52.00	52.50
JPY 🇯🇵	23.15	23.50
KRW 🇰🇷	2.45	2.49

ЗУРХАЙ

2022.10.24 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 29

НАМРЫН ДУНД САРЫН ШАРАГЧИН ТАХИА САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.24-17.48

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Хүрэлцэхүй

ДУРСАМЖ ДҮҮРЭН НЭГЭН ӨДРИЙГ ӨНГӨРҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги сургуулийн шинэ жилийн нээлтээр офицер, ахлагч, ажилтан алба хаагчдыг цугларалт дохиогоор ажиллуулав.

Үүний дараа Зэвсэгт хүчний 2022-2023 оны сургуулийн жилийн нээлтэд цахимаар оролцсон бөгөөд цэргийн алба хаагчид 10 км-ийн явган маршийг үйлдсэн юм. Маршийн үед инженерийн саадад гарц гаргах, хордсон газар орныг туулах, хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэх зэрэг хичээлүүдийг зохион байгуулав.

Сургуулийн жилийг нээж ангийн захирагч хурандаа



У.Буянжаргал нийт бие бүрэлдэхүүнд хандан залуу офицер Г.Мөнхжин хээрийн байрлалд шинэлэг байдлаар зохион байгуулсан тус үйл

ажиллагаанд оролцож, анги хамт олноороо дурсамж бүтээж байгаадаа баяртай байгаагаа илэрхийлж цаашид Зэвсэгт хүчний манлайлагч залуу офицер байхын төлөө хичээж ажиллахаа хэлсэн юм.

Мөн энэ үеэр үйл ажиллагааны өдрийн хооллолтыг аранзны хүнсээр зохион байгуулж "Шилдэг хоол" шалгаруулах уралдаан, "Олс таталт"-ын тэмцээн, урлагийн тоглолтыг нийт бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулж дуу хуур, дурсамж дүүрэн нэгэн өдрийг үлдээ.

Сэтгэл зүйн хангалтын офицер Д.УЯНГАА



10 КИЛОМЕТРИЙН МАРШЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Зэвсэгт хүчний 337 дугаар анги тусгай бэлтгэлийн цогцолбор 10 км-ийн маршийг зохион байгууллаа.

2022-2023 оны сургуулийн жилийг "Залуу офицеруудыг дэмжих жил" болгосонтой холбогдуулан салбаруудыг шинэ төгсөж ирсэн офицерууд удирдан явган маршийг зохион байгуулсан аж.

Ингэснээр залуу боловсон хүчнийг багаар ажиллах чадварт сургахын зэрэгцээ хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 632,912,691

Эдгэрсэн

Нийт: 611,809,650

Нас барсан

Нийт: 6,582,846

Цахим шууданд

ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Ангийн 2022-2023 оны сургуулийн жилийн заах аргын цугларалт амжилттай явагдаж өндөрлөлөө.

Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн 2022-2023 оны сургуулийн жилийн заах аргын цугларалтыг "Цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулах онол, арга зүй" сэдвийн хүрээнд ангийн хээрийн байрлалын районд амжилттай зохион байгуулж явууллаа.

Уг цугларалтад удирдлага, штабын офицерууд, тасаг, албадын дарга нар болон даргалах албан

тушаалын ахлагч нарыг оролцуулан "Удирдах бүрэлдэхүүний манлайлал цэргийн сургалт бэлтгэлд нөлөөлөх нь", "Штабын бэлтгэл, сургалтыг зохион байгуулах арга зүй" "Цэргийн сургалт бэлтгэлийн зорилго, зорилт зохион байгуулах арга зүй", "Сэтгэл зүйн хангалтын үүрэг, зорилго", "ХАБЭА-н ерөнхий ойлголт, туршлага сургамж", Ангийн авто болон замын ажлын техникийн бэлэн байдал, засвар ашиглалт, туршлага сургамж, "Хүний биеийн бүтэц, анатоми, Амилуулах суурь тусламж", "Бүтээн байгуулалтын ажилд оролцсон туршлага сургамж",

гэсэн сэдвүүдээр хичээл сургалтуудыг зохион байгуулахын зэрэгцээ, ангийн нийт бие бүрэлдэхүүний дунд "Байгууллагын үнэт зүйл" сэдвээр нэгдсэн хэлэлцүүлгийг өрнүүллээ.

Цугларалтын төгсгөлд цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 20 км-ын явган маршийг "Ээж хайрхан"-ны чиглэлд зохион байгуулж маршийн явцад тактикийн болон байр зүйн баримжаалал хийх, бүлэг, тасгийн ажиллагаа, татан гаргалт гэсэн сэдвүүдээр сургалтыг зохион байгууллаа.

ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦЛОО



Зэвсэгт хүчний 314 дүгээр анги

Ангийн офицер, даргалах албан тушаалын ахлагч нар 2022-2023 оны сургуулийн жилийн хичээл сургуультай уялдуулан "Шунхлай" ХКК-ний шатахууны төв агуулахын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага солилцоо.

Тус арга хэмжээний хүрээнд даргалах бүрэлдэхүүн агуулахын вагон сткадаас ачиж буулгах төхөөрөмж, автоцистерн,

шатахууныг ачиж буулгах үйл явц, шатахуун тос тослох материалыг стандартын дагуу хадгалсан байдал, шатахууны сав тоног төхөөрөмж, насосын станц, галын системийн аюулгүй үйл ажиллагаа түүний ажиллах зарчим болон шатахууны лабораторийн анхан шатны шинжилгээ хийх үйл явцтай танилцаж мэргэжлийн мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн юм.

Ахмад Э.Мөнхболормаа

ЭЗЭН БОГД ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРГИЙГ ЗАЛЛАА



Зэвсэгт хүчний 032 дугаар анги

2022-2023 оны сургуулийн жилийн нээлтийн арга хэмжээний үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу эзэн Богд Чингис хааны эш хөргийг ангийн хурлын

танхимууддаа тус тус хүндэтгэн заллаа.

Сургуулийн жилийг нээж ангийн захирагч хурандаа М.Болдбаатар хэлсэн үгэндээ "Эх орноо батлан хамгаалах нь хүн нэг

бүрийн цэргийн хэргийн мэдлэг, сэтгэл зүй болон бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин, цэрэг эх оронч төлөвшлөөс хамаардаг" хэмээн онцолсон юм.

Арга хэмжээний үеэр үлээвэр найрал хөгжмийн салааны хөгжимчин ахлагч С.Амартүвшин нийт бие бүрэлдэхүүнд зориулж саксфон хөгжмийн аялгуу, ахлах ахлагч Б.Эрдэнэбаатар ая дууны мэндчилгээг өргөн барилаа.

Үйл ажиллагааны төгсгөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Ардын хувьсгалын 100 жилийн ойн медаль, Батлан хамгаалахын сайдын тушаалаар "Эх орны төлөө III" хүндэт тэмдгээр тус бүр нэг ажилтан албан хаагч шагнагдсныг гардуулан өглөө. Ахмад Т.ДЭЛГЭРМАА

ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦЛОО



Алтангадас одонт, хошууч генерал Ч.Самбуу агсны нэрэмжит Зэвсэгт хүчний 119 дүгээр анги 2022-2023 оны сургуулийн жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа. Уг үйл ажиллагааны

хүрээнд ангийн нийт бие бүрэлдэхүүнийг "Цугларалт" дохиогоор ажиллуулж тусгай үүрэг гүйцэтгэх бүлгүүдийг тодотгохын зэрэгцээ ангийн захирагч дэд хурандаа Г.Дүнжингарав сургуулийн жилийг нээж алба хаагчдад урлаг, спорт, сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөж үг хэлсэн юм.

Мөн энэ үеэр ангийн нийт бие бүрэлдэхүүн 20 км-ийн явган маршийг үйлдэж Хустайн байгалийн цогцолборт газартай танилцлаа.

Ахмад Б.Тэгшбаяр

СУРГАЛТ

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №08


Монгол бичгийн ялгах зурлага

Өмнөх хичээлүүдээр бид монгол бичгийн үсэг бүрдүүлэгч үндсэн 7 зурлагыг үзсэн. Одоо харин ялгах зурлагуудын тухай өгүүлье.

1. ДУСАЛ

Дусал бол На, Га, Ша зэрэг гийгүүлэгчийн ялгах гол зурлага болно. Дуслыг нар буруу эргэсэн хагас дугуй хэлбэрээр бичнэ. Өгүүлбэрт таслалыг дан дуслаар, цэгийг хоёр дуслаар тэмдэглэдэг.

Хоёр дуслыг, эхлээд дээд талынхыг, дараа нь доод талынхыг бичдэг дараалалтай. Дуслыг цэг гэж нэрлэх нь буй боловч дусал нь илүү оновчтой нэр томъёо болмуу.



Зэвсэгт хүчний 325 дугаар анги

2022-2023 оны сургуулийн жилийн нээлтийн арга хэмжээг шинэлэг байдлаар зохион байгууллаа.

Эхний өдөр цугларалт дохиогоор ажиллан, 10 км-ын явган маршийг хичээлийн 4 цэгээр зохион байгуулсан ба цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хэрхэн нэмэгдүүлэх талаар залуу офицер, ахлагч нарын саналыг сонсов.

Тэгвэл дараагийн өдөр нь ангийн захирагч хурандаа Б.Баярсайхан офицерууд болон удирдах албан тушаалын ахлагч нартай

"Манлайлал", "Байгууллагын соёл"-ын талаар сургалт явуулан, хэлэлцүүлэг өрнүүлж, ангийнхаа үнэт зүйлсийг хамтран тодорхойлов.

Мөн манлайлагч офицер, ахлагч болохыг уриалхын зэрэгцээ нийт бие бүрэлдэхүүнд сургуулийн жилийн зорилго, зорилт, удирдах дээд байгууллагаас баримталж буй бодлогыг танилцуулан шинэ хичээлийн жилд нь сурлагын өндөр амжилт хүссэн юм.

ҮНЭТ ЗҮЙЛЭЭ ХАМТРАН ТОДОРХОЙЛОВ

ЗААХ АРГА ЗҮЙН ЦУГЛАРАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги Офицер, ахлагч, ажилчин алба

хаагчдын заах арга зүйн цугларалтыг ангийн байрлалд 3 хоногийн хугацаанд зохион байгуулав.

2022-2023 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөө, стандартын талаар нэгдсэн ойлголтод хүрэх, хичээлийн конспект-төлөвлөгөө, баримт бичгийг стандартын дагуу боловсруулах арга барилд алба хаагчдыг сургах зорилгын хүрээнд офицеруудад 12, ахлагч нарт 11 цагийн хичээлийг нийт 7 багш тусгай хөтөлбөр, төлөвлөгөөгөөр заалаа. Энэ үеэр ангийн захирагч

хурандаа У.Буянжаргал нийт бие бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, алба хаагчдын санал хүсэлтийг сонсож нээлттэй уулзалтыг хийсэн юм.

Мөн энэ үеэр харуулын үзүүлэх хичээлийг ахлах ахлагч Э.Цогтбаяр удирдан явуулав. Уг хичээлүүдийг зохион байгуулснаар ангийн 2022-2023 оны хичээлийн жилийн сургалт, үйл ажиллагаа илүү үр дүнтэй явагдана гэдэгт нийт бие бүрэлдэхүүн итгэл дүүрэн байгаагаа илэрхийлж байсан юм.

Д.Уянгаа